



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 433


Улаанбаатар хот

Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12^{1.2} дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн Хорооны 2016 оны 262, 2017 оны 37 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 12 сарын 24 ны өдрийн
433 дугаар тогтоолын хавсралт



Албан журмын даатгагчдын холбооны
удирдах зөвлөлийн шинэчилсэн бүрэлдэхүүн

№	Дарга, гишүүдийн нэрс	Төлөөлөл
1	Л.Энхтайван Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн	Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл, Удирдах зөвлөлийн дарга
2	З.Батболд Даатгалын газрын Бодлого, зохицуулалтын чиглэлийн ахлах референт	Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл
3	Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга	Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл
4	Б.Жавхлан “Мандал даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал	Даатгагчийн төлөөлөл
5	Ж.Батжаргал Монголын даатгалын холбооны гүйцэтгэх захирал	Даатгагчийн төлөөлөл
6	Б.Эрдэнэбат Тээврийн цагдаагийн албаны Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын хэлтсийн дарга, Цагдаагийн дэд хурандаа	Даатгуулагчийн төлөөлөл
7	М.Бизаагундаа Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал	Даатгуулагчийн төлөөлөл